

Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын үйл ажиллагааны товч мэдээлэл

Д/д	Яам	Сарын онцлох ажил	Тулгамдсан болон хойшлогдож байгаа ажил
1	ХЗЯ	1. Хууль зүйн сайдын 2013 оны А/12 тушаалаар “Шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүсийн тоо бүртгэлийг хөтлөх, лавлагаа олгох заавар”, “Ялтай эсэх лавлагааны Тодорхойлолтын загвар”, “Ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудасны загвар, хууль тогтоомжийн хүрээнд ялтай эсэх лавлагааг “Тодорхойлолт”-оор авах эрх бүхий байгууллагын жагсаалт, “Ял шийтгэлийн тэмдэглэлийн загвар”-ыг тус тус баталсан.	УИХ-ын 2013 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Үүнд: -Гэмт хэргийн тухай хууль -Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль -Цагдаагийн албаны тухай хууль -Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль -Мөрдөх албаны тухай хууль -Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль -Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль -Маршалын албаны тухай
2	ГХЯ	1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн Өмнөд Судан Улсад хийсэн аичлалын бэлтгэлийг хангаж, хэрэгжүүлэв. 2. Засгийн газрын тусгай сангийн (Олон улсын хамтын ажиллагааны сан) тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг УИХ-аар батлав.	1. УИХ-ын дарга З.Энхболдын “Азийн төлөөх Боаогийн чуулга уулзалтын”-ын жилийн уулзалтад оролцох бэлтгэлийг хангах. 2. Монгол-Вьетнам, Монгол-Казахстан, Монгол-Энэтхэг, Монгол-Турк, Монгол-Чех, Монгол-Унгарын ЗГХК-ын хуралдааныг тус тус зохион байгуулах.
3	СЯ	1. Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”, “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны жишиг баримт бичиг”-ийг тус тус батлав. 2. Сангийн сайдын 2013 оны 32/А-21 дүгээр тушаалаар “Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч зах зээлд арилжих журам”-ыг батлав.	1. БНХАУ-ын Засгийн газраас 1958-1960 оны хооронд авсан зээлийн үлдэгдэл болох нийт 28.3 сая шилжих рубль, хоёр улс хоорондын худалдааг клирингийн тооцоогоо хийж байх үед үүссэн 5.6 сая швейцар франкийн өрийн үлдэгдлийн асуудлыг эцэслэн шийдвэрлэх, 1991-1994 оны хооронд авсан нийт 124.1 сая юанийн зээлийн эргэн төлөлтийн хуваарийг шинэчлэх талаар хэлэлцээр хийх. 2. “Эрдэнэт” уулын баяжуулах үйлдвэрээс Бүгд Найрамдах Казахстан Улсын “Балхашмыс” /хуучин нэрээр/ үйлдвэрт 1995-1996 онд нийлүүлсэн 9.5 мян.тн зэсийн баяжмалын авлагын асуудлыг шийдэх.
4	ЗТЯ	1. “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ыг УИХ-ын 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 18 дугаар тогтоолоор батлуулав.	1. “Богдхан төмөр зам” төслийн зураг төслийн санхүүжилтийг шийдвэрлэх. 2. “МИАТ” ТӨХК-ийн захиалсан Б-767 агаарын хөлөг үйлдвэрлэгдэж бэлэн болж байгаа тул төлбөрийг ЭЗХЯ-нд Үндэсний бондын хөрөнгөөр санхүүжүүлэх хүсэлт тавьж санхүүгийн асуудлыг ойрын үед шийдүүлэх.
		1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг	1. ХАХНХ-ын сайдын 2012 оны А/45 тоот тушаалаар байгуулагдсан хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, хүүхдийн

5	ХАХНХЯ	УИХ-аар батлагдав.	хөгжлийг хангах зориулалтаар барьж байгуулсан барилга, байгууламж, бий болгосон хөрөнгийн ашиглалтын өнөөгийн байдлын талаар мэдээлэл бэлтгэх, дүн шинжилгээ хийж Засгийн газарт танилцуулах. 2. Хүн амын асуудлаарх Үндэсний зөвлөл байгуулах.
6	БХЯ	1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ц.Элбэгдоржийн Өмнөд Судан Улсад хийх айлчлалыг 02 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд ажилттай зохион байгуулж, аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулж ажиллав. 2. Цэргийн дүйцүүлэх албаны тооны дээд хязгаар, мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай асуудлыг Засгийн газрын 2013 оны 47 дугаар тогтоолоор батлав.	1. “Монгол Улсын төрийн батлан хамгаалах бодлого” баримт бичгийг УИХ-аар батлуулах. 2. “Цэрэг-техникийн салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Засгийн газраар батлуулах.
7	ЭЗХЯ	1. ТЭЦ-5 төслийн шалгарсан оролцогчдоос хамгийн сайн эцсийн саналаар тодруулга хүлээн авч үнэлэн саналын нөхцөлөөр хэлэлцээ хийсэн. Төслийн концессын гэрээ байгуулах бэлтгэлийг хангасан.	1. ТЭЦ-5 төслийн газрын байгаль орчны нарийвчилсэн үнэлгээг яаралтай хийх, газрын зөвшөөрлийг авах. 2. “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хуулийн журам батлах. 3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах.
8	ХЯ	1. Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтын хүрээнд хөдөлмөрийн бирж, хөдөө орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албатай хамтран улс орон даяар ажил олгогч, ажил хайгчийг нэгдсэн бүртгэлийг хийж, нийт 10000 гаруй ажил хайгч, 6000 гаруй ажил олгогчийг хамруулсан. Бүртгэлд хамрагдсан иргэдийг ажил олгогч ярилцлага хийх замаар сонгон шалгаруулж эхний ээлжинд нийт 5300 гаруй иргэн, 45 МСҮТ, коллежд 5 сарын хугацаагаар элсэн суралцаж байна.	1. Налайх дүүрэгт “Оюу толгой” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Техник технологийн жишиг сургуулийн зам, спорт заал, гадаад тохижилт, багш нарын байр барих зардлыг шийдвэрлэх. 2. Гадаадаас 2013 онд “Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын тогтоол батлуулах. 3. “Ажилтай, орлоготой Монгол хүн” Үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газраар батлуулах.
9	БОНХЯ	1. Бурхан Халдун уулын хамгаалалтыг бэхжүүлэх талаарх талуудын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Дэлхийн ICOMOS-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын төлөөлөгчид, Хэнтий, Төв аймгийн Засаг дарга, ИТХ-ийн дарга нар, холбогдох сумдын Засаг дарга нар, ШУА-ийн Археологийн, газар зүйн хүрээлэнгийн эрдэмтэн	1. "Монполимет" ХХК-иас Төв аймгийн Заамар, Булган аймгийн Бүрэгхангай сумдын заагт (321А) Туул голын хамгаалалтын бүс, голдирол дотор драгаар алт олборлосон үйлдлийг шалгуулж, арга хэмжээ авахуулах хүсэлтийг холбогдох 71 хуудас материалын хамт Улсын мөрдөн байцаах газарт 2013.01.10-ны 9/130 тоотой хүргүүлсэн бөгөөд яаралтай шийдвэрлүүлэх. 2. Байгаль орчны үнэлгээний болон хуримтлах нөлөөлөл,

		судлаачдыг оролцуулан хамтран зөвлөмж гаргав.	стратегийн үнэлгээний журмыг Засгийн газраар батлуулах. 3. Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд газар ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага, зөвшөөрөлгүй газар ашиглаж буй иргэдийн үйл ажиллагаанд шалгалт явуулж газар ашиглалтын байдлын хавсралт зураг, судалгааны материалыг боловсруулж холбогдох арга хэмжээ авах.
10	ЭМЯ	1. Эмнэлгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэх арга хэмжээний хүрээнд Улсын III төв эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төвийн дэргэд гемодиализын тасгийг тус тус шинээр байгуулав.	1. Яамны харьяа байгууллагуудын удирдлагуудын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, томилох.
11	БХБЯ	1. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол”-ыг УИХ-аар батлуулав.	1. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, зээлийн механизмыг шинэчлэх талаар санал боловсруулах. 2. “Газрын тухай”, “Газрын төлбөрийн тухай”, “Газрын кадастрын тухай” хуулиудын шинэчилсэн найруулга, “Геодези, зураг зүйн тухай” хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, “Газар албадан чөлөөлөх тухай” хуулиудыг УИХ-аар батлуулах.
12	ЭХЯ	1. Амгалан дулааны станцыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр шууд гэрээ байгуулан барих асуудлыг Засгийн газрын 2013 оны 55 дугаар тогтоолоор батлав.	1. 2013-2014 оны өвлийн их ачааллын үед Төвийн эрчим хүчний системд ОХУ-аас импортоор авах чадлын хэмжээ, үнэ тариф, гэрээний нөхцлийг тохиролцох. 2. Эрчим хүчний салбар, орон нутаг, харьяа үйлдвэр компаниудын алдагдлыг нөхөх зорилгоор 2013 онд шаардлагатай байгаа санхүүгийн эх үүсвэрийг шийдэх. 3. Тавантолгойн дулааны цахилгаан станц, Дорнодын дулааны цахилгаан станцын өргөтгөлийн ажлыг эхлүүлэх.
13	ССАЖЯ	1. Аялал жуулчлалын тухай хуулийн 16.1.14-д заалтад “аялал жуулчлалын зам чиглэлийг тогтоох” гэж заасны дагуу аймаг, сум, дүүрэг бүрээс саналыг авч явган аялах, алхах 16391 км замын чиглэлийг гаргав.	1. Үлэг гүрвэлийн музейн байрны асуудлыг шийдвэрлэх 2. “Аялал жуулчлалын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах. 3. 2015 онд ХБНГУ-д зохиогдох “Ай Ти Би Берлин-2015” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол Улс түнш орноор оролцох тухай Засгийн газрын тогтоол батлах.
		1. “Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, хяналт тавих, тайлагнах журам”, “Үндэсний боловсруулах	1. 2013 он хаврын тариалалтад шаардагдах цагаан арвай, рапсын үрийг импортоор авах. 2. Хөдөө аж ахуйн биржийг туршилтын журмаар ажиллуулж эхлүүлэх.

14	ҮХААЯ	<p>үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох, хяналт тавих, тайлагнах журам"-ыг Засгийн газрын 2013 оны 48 дугаар тогтоолоор батлав.</p>	<p>3. 2013 оны газар тариалангийн үйлдвэрлэлд 20.3 мянган тонн дизелийн түлшний асуудлыг шийдэх.</p> <p>4. “Чингис хаан бонд”-ын эх үүсвэрээс санхүүжигдэх үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих төслүүдийг эцэслэн шийдвэрлэх.</p> <p>5. “Төрийн өмчийг 2013-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон үзэл баримтлалын төслийг танилцуулгын хамт боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.</p>
15	УУЯ	<p>1. Оюутолгойн баяжуулах үйлдвэрээс экспортлох зэс-алтны баяжмалд хөндлөнгийн хяналт тавих зорилгоор лабораторийн нэгж байгуулах асуудлыг Засгийн газрын 2013 оны 44 дүгээр тогтоолоор батлав.</p>	<p>1. Монгол Улсад шатдаг занар эрэх, хайх, олборлох, боловсруулах, ашиглах асуудлыг судлан, нийлэг газрын тос, хийн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, “Шатдаг занар” бодлого, хөтөлбөрийн төсөл боловсруулах.</p> <p>2. “Нүүрсний салбарын хөгжлийн Мастер төлөвлөгөө” боловсруулах.</p> <p>3. Алт олборлож угаах, хүлээлцэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, улсад тушаах, борлуулах журмын төслийг боловсруулах.</p>
16	БШУЯ	<p>1. Улсын төсвөөс олгох “Үндэсний болон урамшууллын тэтгэлэгийг суралцагчийн картын дансаар олгох түр журам”-ыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/38 тушаалаар баталж, тэтгэлгийг олгох ажлыг шуурхай болгов.</p>	<p>1. “Монгол судлалыг дэмжих сан” байгуулах зорилгоор Тусгай сангийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийг УИХ-аар батлуулах.</p> <p>2. Сургалтын төрийн сангийн зээлийн эргэн төлөлт, чөлөөлөлт, хөнгөлөлтийн журмыг шинэчлэн Засгийн газраар батлуулах.</p> <p>3. Герман-Монголын технологийн дээд сургууль байгуулах асуудлыг шийдэх.</p>

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР